



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН
ТОГТООЛ

2019 оны 08 сарын 29 өдөр

Дугаар 345

Улаанбаатар хот

Үндсэн хөрөнгө балансаас балансад
шилжүүлэх тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8, 30 дугаар зүйлийн 2 дахь хэсэг, 31 дүгээр зүйлийн 1, 3 дахь хэсэг, Засгийн газрын 2019 оны 168 дугаар тогтоол, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор баталсан "Төрийн болон орон нутгийн өмчид эд хөрөнгө олж авах, бүртгэх, данснаас хасах, шилжүүлэх журам"-ын 5.1, 8 дахь заалтыг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. "Монголросцветмет" төрийн өмчит үйлдвэрийн газрын үндсэн хөрөнгөд бүртгэлтэй, нийт 136,012,950.00 (нэг зуун гучин зургаан сая арван хоёр мянга есөн зуун тавин) төгрөгийн балансын үнэ, 129,272,508.22 (нэг зуун хорин есөн сая хоёр зуун далан хоёр мянга таван зуун найман төгрөг хорин хоёр мөнгө) төгрөгийн хуримтлагдсан элэгдэл бүхий хавсралтад заасан үндсэн хөрөнгийг "Хөвсгөл-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанид балансаас балансад шилжүүлсүгэй.

2. Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын Захиргаа, хууль зүйн хэлтсийн даргын үүргийг түр орлон гүйцэтгэх Б.Эрдэнэбаяр, "Монголросцветмет" төрийн өмчит үйлдвэрийн газрын захирал Б.Мөнхбат, "Хөвсгөл-АЗЗА" төрийн өмчит хувьцаат компанийн гүйцэтгэх захирал нарт Б.Галбадрах нарт дор дурдсан арга хэмжээ авч ажиллахыг даалгасугай:

2.1. Хөрөнгө хүлээлцэх ажлыг холбогдох хууль тогтоомж, журмын дагуу байгууллагынхаа өмч хамгаалах Байнгын зөвлөлийн хяналт дор зохион байгуулах;

2.2. Хөрөнгийн хөдлөлийг зохих хууль тогтоомж, журмын дагуу нягтлан бодох бүртгэл, тайланд тусган, "Төрийн болон орон нутгийн өмчийн удирдлагыг мэдээлэлжүүлэх систем"-д бүртгэх;

2.3. Арга хэмжээний биелэлтийг 2019 оны 3 дугаар улиралд багтаан ирүүлэх.

3. Энэ тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн бүртгэл, хяналтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т үүрэг болгосугай.

ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

ЗАХИРГАА, ХУУЛЬ ЗҮЙН ХЭЛТСИЙН
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ
ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ

А.АРИУНБОЛД

Б.ЭРДЭНЭБАЯР

000065

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2019 оны 08 дугаар сарын 19-ны өдрийн
445 дугаар тогтоолын хавсралт

"МОНГОЛПРОСЦВЕТМЕТ" ТӨРИЙН ӨМЧИТ ҮЙЛДВЭРИЙН ГАЗРЫН ҮНДСЭН
ХӨРӨНГӨД БҮРТГЭЛТЭЙ, "ХӨВСГӨЛ-АЗЗА" ТӨРИЙН ӨМЧИТ ХУВЬЦААТ
КОМПАНИД БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Автомашины нэр, марк, улсын бүртгэлийн дугаар, арлын дугаар	Ашиглалтад орсон огноо	Балансын нийт үнэ (төгрөг)	Хуримтлагдсан элэгдэл (төгрөг)	Үлдэгдэл өртөг (төгрөг)
1	Лексус 570, 01-70 УНП (арал-jtjhy00wx04017284)	2013.08.31	136,012,950.00	129,272,508.22	6,740,441.78
	Нийт дүн		136,012,950.00 (нэг зуун гучин зургаан сая арван хоёр мянга есөн зуун тавин)	129,272,508.22 (нэг зуун хорин есөн сая хоёр зуун далан хоёр мянга таван зуун найман төгрөг хорин хоёр мөнгө)	6,740,441.78 (зургаан сая долоон зуун дөчин мянга дөрвөн зуун дөчин нэгэн төгрөг далан найман мөнгө)